

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	2-3
2.	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагааны, хууль, эрх зүйн орчин	5-6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3.	Менежментийн захидал	11
3.1	Томилолтын талаар	11
3.1.1	Илрүүлэлт:	11
3.1.2	Эрсдэл:	11
3.1.3	Өгсөн зөвлөмж:	11
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	11
3.2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар	12
3.2.1	Илрүүлэлт:.....	12
3.2.2	Эрсдэл:	12
3.2.3	Өгсөн зөвлөмж:	12
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	12
3.3	Авлагын талаар	12
3.3.1	Илрүүлэлт:	12
3.3.2	Эрсдэл:	12
3.3.3	Өгсөн зөвлөмж:	12
3.3.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	12
4.	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13-15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16-18
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	19-21
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	22
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	23-25
4.6	Зөрчлийн нэгтгэл.....	26-27

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.25 № 06/253
танай _____-ны № _____-т

МАЛЫН УДМЫН САНГИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Д.ЦОЛМОН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Малын удмын сангийн үндэсний төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн захирал Д.Цолмон танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 20-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Лидер экаунт аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Лхамсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Малын удмын сангийн үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Малын удмын сангийн үндэсний төв нь Мал сүргийг генийн түвшинд төрийн хамгаалалтад авч, малын үржлийн ажил, үйлчилгээнд биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилтэт аргыг нэвтрүүлсэнээр малын ашиг шим, бүтээмжийг нэмэгдүүлэн мах, сүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, улмаар мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны А/187 дугаар тушаалаар “Малын удмын сангийн үндэсний төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийг баталсан байна. Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал сүргийн удмын санг хамгаалах, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах, мал үржүүлэг, нөхөн үржихүйн чиглэлээр гаргасан эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;
- Арвин ашиг шимт хээлтүүлэгч малын үр, хөврөл үрийг үйлдвэрлэх, үйлдвэр, үйлчилгээнд нэвтрүүлэх;
- Мал хээлтүүлгийн ажил, үйлчилгээнд орчин үеийн шинэ технологийг нэвтрүүлэх, энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, мэдээллээр хангах;
- Арвин ашиг шимтэй малын үр, хөврөл үрийг нөөцлөх, генийн сан бий болгох;
- Цөм сүргийн үржлийн төв, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг үр, хөврөл үрээр хангах;
- Үржилд ашиглах шилмэл хээлтүүлэгчийг ашиг шим, үр төлийн чанараар шалгаруулах;
- Өндөр ашиг шимт хээлтүүлэгч малын үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажил, үйлчилгээ явуулах, тухайн үүлдрийн шилмэл ангийн жишигт нийцсэн хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулах;
- Аймаг, нийслэл, бүс нутгийн хэмжээнд гойд ашиг шимт малын үзэсгэлэн, дуудлага худалдаа зохион байгуулах;
- Тоо нь цөөрч удмын сан нь алдагдах хэмжээнд хүрсэн мал, амьтны үрийг нөөцлөх, удмын санг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх;
- Улсын хэмжээнд үржүүлж байгаа арвин ашиг шимт цөм сүргийн малын удам гарвал, ашиг шимийн мэдээллийн сан бий болгож, дүн шинжилгээ хийх.

Малын удмын сангийн үндэсний төв үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Малын удмын сангийн үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Малын генетик нөөцийн тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 188 дугаар тогтоолоор “Малын удмын сангийн үндэсний төв” аж ахуйн тооцоот улсын үйлдвэрийн газрыг малын үндэсний генийн санг САГ-2019/162/СТА-ТШЗ

хамгаалах, сайжруулах үндсэн чиг үүрэг бүхий “Малын удмын сангийн үндэсний төв” улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяанд ажиллуулахаар шийдвэрлэсэн байна.

2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцүүлж, шинэчлэх шаардлагатай.

Малын удмын сангийн үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Малын удмын сангийн үндэсний төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Малын удмын сангийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аудитын явцад Малын удмын сангийн үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Төсөвт байгууллагад санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үед голчлон төсөвт хөрөнгийн зарцуулалтыг авч үзэх учраас материаллаг байдлын түвшинг нийт зардлын 1 хувиар тооцсон.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгийн дүн өндөр байгаа тул байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны нийт зардал 1,704,560.8 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 17,046.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Төсөвт байгууллагад санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын үед голчлон төсөвт хөрөнгийн зарцуулалтыг авч үзэх учраас материаллаг байдлын түвшинг нийт зардлын 1 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	/мянган төгрөгөөр/	
			Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	131,685.7	
Дүн		3	131,685.7	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулав.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Малын удмын сангийн үндэсний төв чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдон 2018 онд улсын төсвөөс 777,743.9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Малын удмын сангийн үндэсний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус төв төсвийн орлого зарлага түүний хэмнэлт хэтрэлтийг сар бүр, 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5,000.0

мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг хуулийн дагуу мэдээлж ирсэн байна.

2.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж, 2 зөвлөмж 60-90 хувьтай байна.

Гүйцэтгэл дутуу байгаа гол шалтгаан нь эзэн холбогдогч нь нас барсан, тухайн үеийн Төрийн өмчийн хорооноос шилжиж ирсэн найдваргүй авлага нотлох баримтгүйгээс барагдуулах боломжгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Малын удмын сангийн үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Томилолтын талаар

3.1.1 Илрүүлэлт:

Дотоод томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны тооцоо бодсон акт /томилолт/ үйлдээгүй нийт 1,840.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 34 дугаар тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Хууль тогтоомж, зөрчигдөх эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Томилолтын зардлыг хууль журмын дагуу тооцож, тайлагнах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/92 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зайлшгүй байвал зохих бодлогын горимууд, болон мөрдөгдсөнөөс хойших хугацааны нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг оруулж, шинэчлэх шаардлагатай байна.

3.2.2 Эрсдэл:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх заалтыг мөрдөж ажиллах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хуульд заасны дагуу бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Авлагын талаар

3.3.1 Илрүүлэлт:

2009-2013 оны хооронд үүссэн нэр бүхий иргэдээс мал дутагдсаны авлага 11,097.6 мянган төгрөг, 2014-2016 оны хооронд үүссэн малын түүхий эдийн 16,314.1 мянган төгрөг, эзэн холбогдогч нь нас барсан 47,684.2 мянган төгрөг, тухайн үеийн Төрийн өмчийн хороо /хуучнаар/ ноос 2013 онд шилжиж ирсэн 54,749.3 мянган төгрөгийн, нийт 129,845.2 мянган төгрөгийн найдваргүй авлага тус тус байна.

3.3.2 Эрсдэл:

Стандарт, хууль, журам зөрчигдөх эрсдэлтэй.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Найдваргүй авлагыг барагдуулах талаар хуулийн байгууллага болон холбогдох яаманд тавьж, шийдвэрлүүлэх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	986,551,644.22	1,333,222,323.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
31110	Төгрөг		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		
3121	Төгрөг		
33	АВЛАГА	157,007,097.88	196,479,645.28
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
335	Бусад авлага	157,007,097.88	196,479,645.28
3351	Байгууллагаас авах авлага	22,829,792.75	48,330,764.35
3352	Хувь хүмүүсээс авах авлага	134,177,305.13	148,148,880.93
35	БАРАА МАТЕРИАЛ	829,544,546.34	1,136,742,678.55
351	Түүхий эд материал	323,125,348.13	340,006,194.95
35110	Тусгай зориулалттай материал	59,941,959.42	110,400,083.42
35130	Эм боох материал	678,550.00	
35300	Бэлэн бүтээгдэхүүн	262,504,838.71	229,606,111.53
354	Хангамжийн материал	506,419,198.21	796,736,483.60
35410	Бичиг хэргийн материал	1,604,550.00	
35420	Аж ахуйн материал	33,284,500.00	58,687,606.09
35430	Сэлбэг хэрэгсэл	775,000.00	775,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,750,127.53	3,881,473.53
35460	Хүнсний материал	34,115,150.00	24,303,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,467,118.40	17,926,544.50
35600	Мал амьтад	424,422,752.28	691,162,859.48
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,773,735,374.02	18,514,568,203.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,773,735,374.02	18,514,568,203.80

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

392	Биет хөрөнгө	15,772,796,936.52	17,624,999,716.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,735,218,873.60	14,531,830,823.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(461,928,803.79)	(378,165,594.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	245,818,788.60	226,618,788.60
39204	Хуримтлагдсан элэгдэл	(210,470,939.40)	(190,434,034.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,535,360,276.08	3,721,533,852.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	(697,390,875.92)	(921,793,929.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	106,536,051.49	578,896,351.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	(68,368,967.54)	(78,063,953.45)
39214	Бусад үндсэн хөрөнгө		178,242,924.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(73,907,155.95)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,588,022,533.40	30,241,644.40
393	Биет бус хөрөнгө	938,437.50	889,568,487.50
39301	Програм хангамж	3,026,000.00	3,026,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,087,562.50)	(2,376,312.50)
39303	Бусад биет бус хөрөнгө		888,918,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>16,760,287,018.24</u>	<u>19,847,790,527.63</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>77,791,491.16</u>	<u>15,319,221.61</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	77,791,491.16	15,319,221.61
412	Богино хугацаат зээлийн өглөг	20,328,000.00	
4121	Төгрөг	20,328,000.00	
41214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	20,328,000.00	
413	Өглөг	57,463,491.16	15,319,221.61
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	38,952,370.20	11,392,984.88
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		107,142.40
4136	Бусад өглөг	18,511,120.96	3,819,094.33

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

41361	Байгууллагад төлөх өглөг	14,182,239.13	2,958,685.32
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,328,881.83	860,409.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,682,495,527.08	19,832,471,306.02
51	Засгийн газрын хувь оролцоо	16,682,495,527.08	19,832,471,306.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	715,152,135.15	1,604,070,935.15
51101	Өмч: - төрийн	715,152,135.15	1,604,070,935.15
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
512	Хуримтлагдсан үр дүн	15,921,907,711.93	17,619,466,006.47
51210	Өмнөх үеийн үр дүн	12,337,913,794.50	15,936,170,747.93
51220	Тайлант үеийн үр дүн	3,583,993,917.43	1,683,295,258.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,435,680.00	608,934,364.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>16,760,287,018.24</u>	<u>19,847,790,527.63</u>

4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,182,208,985.49	2,991,278,211.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,529,859,919.54	2,423,696,011.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,529,859,919.54	2,423,696,011.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,529,859,919.54	2,423,696,011.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,395,149.18	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		19,178,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,526,464,770.36	2,404,518,011.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/		
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/		
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	652,349,065.95	567,582,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	498,618,200.00	525,662,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	498,618,200.00	525,662,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	153,730,865.95	41,920,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	25,577,400.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,710,000.00	41,920,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	86,443,465.95	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,383,023,520.83	1,704,560,806.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,383,023,520.83	1,704,560,806.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,293,751,740.88	1,625,291,168.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	322,316,970.88	278,713,825.09
210101	Үндсэн цалин	265,773,079.61	225,557,669.78
210102	Нэмэгдэл	34,433,891.27	32,106,155.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,110,000.00	21,050,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,923,716.15	33,378,085.98
210201	Тэтгэврийн даатгал	33,923,716.15	22,828,764.80

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал		2,806,967.50
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,945,187.86
210204	Ажилгүйдлийн даатгал		527,015.06
210205	Эрүүл мэндийн даатгал		5,270,150.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,075,562.00	87,832,391.91

210301	Гэрэл, цахилгаан	7,727,522.00	10,958,328.00
210302	Түлш, халаалт	20,831,800.00	70,666,743.91
210303	Цэвэр, бохир ус	316,240.00	3,807,320.00
210304	Байрны түрээс	4,200,000.00	2,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,814,543.40	29,692,721.36
210401	Бичиг хэрэг	3,395,530.00	3,914,750.00
210402	Тээвэр, шатахуун	22,452,558.00	18,406,585.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,632,532.00	3,781,756.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,072,856.00	3,589,630.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал	18,261,067.40	
2105	Нормативд зардал	14,304,240.00	4,504,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,320,440.00	678,550.00
210502	Хоол, хүнс	4,075,800.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,908,000.00	3,825,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,344,849.00	8,024,480.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,214,200.00	2,096,900.00
210604	Урсгал засвар	7,130,649.00	5,927,580.00
2107	Томилолт, зочны зардал	18,781,630.14	14,152,282.00
210701	Гадаад албан томилолт	9,800,000.00	9,975,652.00
210702	Дотоод албан томилолт	8,981,630.14	4,176,630.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,034,332.66	129,069,599.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,432,263.66	128,446,799.69

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	726,615.00	536,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	
210807	Газрын төлбөр	778,104.00	86,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	779,155,896.65	1,039,923,732.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	551,079,945.81	473,594,769.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	76,662,663.18	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	151,413,287.66	566,328,962.55
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,271,779.95	79,269,638.25
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,064,000.00	2,675,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,200,000.00	2,675,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,864,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,207,779.95	76,594,638.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,207,779.95	76,594,638.25
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>3,799,185,464.66</u>	<u>1,286,717,404.59</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	60,926,816.20	399,859,633.02
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	60,926,816.20	399,859,633.02
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	276,118,363.41	3,281,779.07
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	276,118,363.41	
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		3,281,779.07
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(215,191,547.21)	396,577,853.95
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>3,583,993,917.45</u>	<u>1,683,295,258.54</u>

4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>716,831,674.98</u>	<u>764,133,327.72</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО		
110	Орлогын албан татвар		
1100	Хувь хүний орлогын албан татвар		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,004,842.50	196,551,127.72
120	Нийтлэг татварын бус орлого	18,004,842.50	196,551,127.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,004,842.50	196,551,127.72
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,004,842.50	25,283,712.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		171,267,414.92
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	698,826,832.48	567,582,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	498,618,200.00	525,662,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	498,618,200.00	525,662,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	200,208,632.48	41,920,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	25,577,400.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,710,000.00	41,920,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	132,921,232.48	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>683,578,539.23</u>	<u>757,433,327.72</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	683,578,539.23	757,433,327.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	595,206,759.28	678,163,689.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	317,562,802.44	278,713,825.09
210101	Үндсэн цалин	261,018,911.17	225,557,669.78
210102	Нэмэгдэл	34,433,891.27	32,106,155.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,110,000.00	21,050,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,410,271.47	33,378,085.98
210201	Тэтгэврийн даатгал	33,410,271.47	22,078,796.90
210202	Тэтгэмжийн даатгал		2,806,967.50
210203	ҮОМШӨ-ний даатгал		1,945,187.86
210204	Ажилгүйдлийн даатгал		527,015.06
210205	Эрүүл мэндийн даатгал		6,020,118.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,617,679.00	78,168,248.00
210301	Гэрэл, цахилгаан	7,832,824.00	10,958,328.00
210302	Түлш, халаалт	16,014,775.00	61,002,600.00
210303	Цэвэр, бохир ус	570,080.00	3,807,320.00

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210304	Байрны түрээс	4,200,000.00	2,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,059,673.53	24,982,497.36
210401	Бичиг хэрэг	4,210,700.00	2,310,200.00
210402	Тээвэр, шатахуун	27,143,585.53	15,300,911.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,632,532.00	3,781,756.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,072,856.00	3,589,630.00
2105	Нормативд зардал	14,049,790.00	3,825,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,998,990.00	
210502	Хоол, хүнс	4,025,800.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,025,000.00	3,825,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,728,849.00	7,858,480.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,678,200.00	1,938,900.00
210604	Урсгал засвар	7,050,649.00	5,919,580.00
2107	Томилолт, зочны зардал	18,781,630.14	14,152,282.00
210701	Гадаад албан томилолт	9,800,000.00	9,975,652.00
210702	Дотоод албан томилолт	8,981,630.14	4,176,630.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,901,333.30	182,338,921.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,230,784.30	181,716,121.04
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	824,115.00	536,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	727,084.00	86,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,094,730.40	54,745,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102,604,730.40	54,745,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	490,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,164,000.00	2,675,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,200,000.00	2,675,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,964,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,207,779.95	76,594,638.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,207,779.95	76,594,638.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>33,253,135.75</u>	<u>6,700,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	40,749,600.00	6,700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,749,600.00	6,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	40,749,600.00	6,700,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	40,749,600.00	6,700,000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(40,749,600.00)</u>	<u>(6,700,000.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(7,496,464.25)	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,496,464.25	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь Оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,297,739,410.98	45,435,680.00	11,733,910,153.51		13,077,085,244.49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			604,003,640.97		604,003,640.97
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,297,739,410.98	45,435,680.00	12,337,913,794.48		13,681,088,885.46
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-582,587,275.83				-582,587,275.83
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
C07	Тайлант үеийн үр дүн			3,583,993,917.45		3,583,993,917.45
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	715,152,135.15	45,435,680.00	15,921,907,711.93		16,682,495,527.08
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	715,152,135.15	45,435,680.00	15,921,907,711.93		16,682,495,527.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			14,263,036.00		14,263,036.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	715,152,135.15	45,435,680.00	15,936,170,747.93		16,696,758,563.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		563,498,684.40			563,498,684.40
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	888,918,800.00				888,918,800.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					
D08	Тайлант үеийн үр дүн			1,683,295,258.54		1,683,295,258.54
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,604,070,935.15	608,934,364.40	17,619,466,006.47		19,832,471,306.02

4.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	777,743,900.00	650,321,291.97	(127,422,608.03)	(16.38)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	777,743,900.00	650,321,291.97	(127,422,608.03)	(16.38)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	774,543,900.00	647,646,291.97	(126,897,608.03)	(16.38)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,226,700.00	278,713,825.09	(6,512,874.91)	(2.28)
210101	Үндсэн цалин	246,865,700.00	225,557,669.78	(21,308,030.22)	(8.63)
210102	Нэмэгдэл	18,811,300.00	32,106,155.31	13,294,855.31	70.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,549,700.00	21,050,000.00	1,500,300.00	7.67
210104	Урамшуулал	-	-		
210105	Гэрээт ажлын хөлс	-	-		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,243,700.00	33,378,085.98	(865,614.02)	(2.53)
210201	Тэтгэврийн даатгал	22,834,600.00	22,078,796.90	(755,803.10)	(3.31)
210202	Тэтгэмжийн даатгал	2,852,300.00	2,806,967.50	(45,332.50)	(1.59)
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,281,900.00	1,945,187.86	(336,712.14)	(14.76)
210204	Ажилгүйдлийн даатгал	570,400.00	527,015.06	(43,384.94)	(7.61)
210205	Эрүүл мэндийн даатгал	5,704,500.00	6,020,118.66	315,618.66	5.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,208,800.00	78,168,248.00	(60,040,552.00)	(43.44)
210301	Гэрэл, цахилгаан	16,274,400.00	10,958,328.00	(5,316,072.00)	(32.67)
210302	Түлш, халаалт	104,013,000.00	61,002,600.00	(43,010,400.00)	(41.35)
210303	Цэвэр, бохир ус	15,642,000.00	3,807,320.00	(11,834,680.00)	(75.66)
210304	Байрны түрээс	2,279,400.00	2,400,000.00	120,600.00	5.29
2104	Хангамж, бараа материалын зардал	24,866,600.00	24,447,697.36	(418,902.64)	(1.68)
210401	Бичиг хэрэг	3,006,600.00	1,950,200.00	(1,056,400.00)	(35.14)

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	15,340,000.00	15,300,911.00	(39,089.00)	(0.25)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,340,000.00	3,606,956.36	266,956.36	7.99
210404	Ном, хэвлэл	-	-		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,180,000.00	3,589,630.00	409,630.00	12.88
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-		
2105	Нормативд зардал	4,000,000.00	3,825,500.00	(174,500.00)	(4.36)
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-		
210502	Хоол, хүнс	-	-		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	3,825,500.00	(174,500.00)	(4.36)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,607,300.00	7,562,480.00	(44,820.00)	(0.59)
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,573,800.00	1,642,900.00	(930,900.00)	(36.17)
210602	Тавилга	-	-		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-		
210604	Урсгал засвар	5,033,500.00	5,919,580.00	886,080.00	17.60
2107	Томилолт, зочны зардал	3,006,400.00	2,623,230.00	(383,170.00)	(12.75)
210701	Гадаад албан томилолт	-	-		
210702	Дотоод албан томилолт	3,006,400.00	2,623,230.00	(383,170.00)	(12.75)
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	227,065,700.00	170,881,375.54	(56,184,324.46)	(24.74)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	224,699,700.00	170,258,575.54	(54,441,124.46)	(24.23)
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-		
210803	Даатгалын үйлчилгээ	-	-		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	750,000.00	536,400.00	(213,600.00)	(28.48)
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	-		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-		
210807	Газрын төлбөр	1,616,000.00	86,400.00	(1,529,600.00)	(94.65)

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,318,700.00	48,045,850.00	(2,272,850.00)	(4.52)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,318,700.00	48,045,850.00	(2,272,850.00)	(4.52)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,200,000.00	2,675,000.00	(525,000.00)	(16.41)
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-		
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,200,000.00	2,675,000.00	(525,000.00)	(16.41)
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,200,000.00	2,675,000.00	(525,000.00)	(16.41)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	778,743,900.00	653,646,631.35	(125,097,268.65)	(16.06)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	525,662,200.00	457,095,503.63	(68,566,696.37)	(13.04)
131001	Улсын төсвөөс санхүүжих	525,662,200.00	457,095,503.63	(68,566,696.37)	(13.04)
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-		
132001	Орон нутгийн төсвөөс	-	-		
1330	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	253,081,700.00	196,551,127.72	(56,530,572.28)	(22.34)
133001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,550,000.00	25,283,712.80	(6,266,287.20)	(19.86)
133002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	221,531,700.00	171,267,414.92	(50,264,285.08)	(22.69)
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	34	33		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	33	32		
620003	Үйлчлэх ажилтан	-			
620004	Гэрээт ажилтан	-	-		

4.6 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.02.22	Аудитын нэр:	Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/179/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Малын удмын сангийн үндэсний төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	З	4	5	9	10
1	2009-2013 оны хооронд үүссэн нэр бүхий иргэдээс мал дутагдсаны авлага 11,097.6 мянган төгрөг, 2014-2016 оны хооронд үүссэн малын түүхий эдийн 16,314.1 мянган төгрөг, эзэн холбогдогч нь нас барсан 47,684.2 мянган төгрөг, тухайн үеийн Төрийн өмчийн хороо /хуучнаар/-оос 2013 онд шилжиж ирсэн 54,749.3 мянган төгрөгийн, нийт 129,845.2 мянган төгрөгийн найдваргүй авлага тус тус байна.	129,845.2	Зөвлөмж	Төрийн өмчийн хорооны тухайн үеийн удирдлага	
2	Дотоод томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны тооцоо бодсон акт /томилолт/ үйлдээгүй нийт 1,840.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-нй өдрийн 347 тоот тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1,840.50	Зөвлөмж	Захирал	Д.Цолмон
				Нягтлан бодогч	Б.Таван-Эрдэнэ

Малын удмын сангийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	<p>Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/92 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зайлшгүй байвал зохих бодлогын горимууд, болон мөрдөгдсөнөөс хойших хугацааны нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг оруулж, шинэчлэх шаардлагатай байна.</p>		Зөвлөмж	Нягтлан бодогч	Б.Таван-Эрдэнэ
Дүн	131,685.7				